

## Албан бичиг баримт

ТОМУУГИЙН ЦАРТАХЛЫН ДАРААХИ ҮЕ ШАТАНД  
ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЛААР ДЭМБ-ЫН ЗӨВЛӨМЖ

2010 оны 8 дугаар сарын 10, Женева хот

Дэлхий дахин одоо томуугийн цартахлын дараахи үе шатанд орлоо. Томуугийн өмнөх цартахлуудын жишгээс үзвэл томуугийн А(Н1N1) 2009 вирус цаашдаа ч нэг хэсэг хүн амын дотор орчиж, улирлын чанартай өвчлөлийн шалтгаан болсоор байх болно. Хэдүйгээр энэ вирусийн цартахлын аюул эрсдэл ихээхэн буурсан боловч, гишүүн улс орнуудын үндэсний эрүүл мэндийн албад тандалтын үйл ажиллагаагаа сулруулахгүй байх нь чухал. Ялангуяа цартахлын дараахи гэж нэрлэж байгаа энэ үе шатны эхэн хэсэгт А(Н1N1) 2009 вирусийн цаашдын хувьслын зүй тогтол бүрэн тодорхой болоогүй байгаа тул тандалтын ач холбогдол нэн чухал болно.

Тухайлбал, А(Н1N1) 2009 вирус цартахлын дараахи шатны эхэн үед бага насны хүүхдийн дунд амьсгалын өвчний дэгдэлтийн шалтгаан байсаар байх магадлалтай. Хэдүйгээр хамралт нь ихээхэн багасах боловч, цартахлын ид үед илүү хүндрэлтэй өвчлөх магадлал өндөр байсан хүн амын давхруудад энэ эрсдэл нь нэг хэсэгтээ хэвээр үргэлжлэх болно. Цартахлын вирус цөөхөн зарим хүний уушгины эдэд шууд үржин үрэвсүүлж, ноцтой хүнд өвчлөл үүсгэж болдог, уг эмгэг эмчилгээ авахдаа нэн муу болохыг саяын цартахлын үеэр олж мэдсэн бөгөөд энэ байдал цаашид үргэлжлэх эсэхийг одоогоор хэн ч хэлж мэдэхгүй байна.

ДЭМБ-ын энэ зөвлөмж нь цартахлын дараахи үед гишүүн орнууд томуугийн эпидемиологийн болон вирус судлалын тандалт, томуугийн эсрэг вакцинжуулалт, томуугийн эмчилгээний зарчмын талаар баримтлавал зохих гол чиглэлийг заасан болно.

А(Н1N1) 2009 вирус цаашид ч хүн амын дотор орчиж, өвчлөл үүсгэсээр байх болно гэдгийг үндэсний эрүүл мэндийн албад юуны өмнө анхааралдаа авах ёстой.

Цартахлын дараахи үед Үндэсний эрүүл  
мэндийн албадад өгөх ДЭМБ-ын зөвлөмж

## Амьсгалын замын халдварын тандалт

ь

Цартахлын дараахи үед үндэсний эрүүл мэндийн албад дараахи чиглэлээр тандалт хийж байхыг ДЭМБ зөвлөж байна:

- Амьсгалын замын ердийн бусын (гаж) тархалттай буюу эмнэлзүйн илрэлтэй өвчлөл, нас баралтын тандалт;

- Хүндрэл ихтэй томуу болон ерийн бус илрэлтэй томуу-төст өвчний тохиолдол болон дэгдэлтийн шалтгааныг хурдан тогтоох;

- Амьсгалын замын халдварын, тухайлбал, ТТӨ (ILI), амьсгалын замын хүндэрсэн халдвар(sARI)-ын тандалтыг тасралтгүй хэрэгжүүлэх;

- FluID, FluNet, болон EUROFlu зэрэг өвчлөлийн мэдээллийн сангуудад мэдээгээ тогтмол өгөх;

- Дараахи тохиолдлуудад ДЭМБ-д яаралтай мэдээлэх, үүнд:

- о вирусийн эсрэг бэлдмэлд тэсвэржсэн томуугийн А(Н1N1) 2009 омгууд хүн амын дунд идэвхитэй орчиж эхлэвэл,

- о хүн амын дунд одоо орчилд орохгүй байгаа томуугийн шинэ омог орчилд орж, хүний өвчлөл үүсгэж эхлэвэл,

- о томуугийн А(Н1N1) 2009 вирусийн тархалтын насны бүлэг, эмнэлзүйн төрх, эмийн бодист тэсвэржилт зэрэг эпидемиологийн болон эмнэлзүйн шинж эрс өөрчлөгдөх шинж гарвал.

- томуугийн А(Н1N1) 2009 вирусийн удамшлын, эсрэгтөрөгчийн болон эмийн бодист мэдрэг чанар зэрэг биологийн төрхийн өөрчлөлтийг тандан хянаж байх.

<sup>1</sup>Эх нь: WHO recommendations for the post-pandemic period, [http://www.who.int/csr/disease/swineflu/notes/briefing\\_20100810/en/index.html](http://www.who.int/csr/disease/swineflu/notes/briefing_20100810/en/index.html);

**Вакцинжуулалт**

Томуугийн вирусээр сэдээдсэн өвчлөл, эндэгдлийг хяналтанд авах гол арга нь вакцинжуулалт байх болно. Тиймээс хүн амынхаа эмзэг давхрынхныг томуугийн вакцинжуулалтанд хамруулж байхыг ДЭМБ гишүүн орнууддаа онцлон зөвлөж байна.

Дэлхий дахинд тархан цартахал үүсгэсэн томуугийн А(Н1N1) 2009 вирус хүн амын дотор одоо ч орчсоор байгаа тул энэ вирусийг найрлагандаа багтаасан улирлын<sup>2</sup> гурван-цэнт вакцин олдоцтой улс орнуудад энэ вакциныг томуугаас сэргийлэх зорилгоор хэрэглэх нь зүйтэй. Гурван-цэнт вакцин олдоцгүй улс орнуудад томуугийн А(Н1N1) 2009 вирусийн эсрэг нэг-цэнт вакциныг хэрэглэх нь томуугаас уламжилсан хүндрэл, эндэгдлийг бууруулна гэж ДЭМБ үзэж байна.

Томуугийн А(Н1N1) 2009 вирусийн эсрэг нэг-цэнт вакциныг хэрэглэхдээ Үндэсний зохицуулах албадын удирдамжийг баримтлах нь зүйтэй бөгөөд цаашид нөхцөл байдал хувиран өөрчлөгдөх аваас энэ талаар ДЭМБ Стратегийн Зөвлөх Экспертүүдийн Бүлгийн (SAGE) зөвлөмжийг удирдлага болгох болно.

**Эмчилгээ**

Томуугаар өвчилсөн буюу өвчилсөн байж болзошгүй хүмүүс тохирсон эмчилгээ хийлгэх шаардлагатай. Энэ талаар ДЭМБ-ын удирдамжийг эмч нар ашиглаж болно. Томуугийн А(Н1N1) 2009 вирус орчилд байсаар байх нь тодорхой тул эмнэлзүйн янз бүрийн илрэлтэй өвчлөл сэдээсээр байх нь тодорхой. Тиймээс өвчнийг цаг алдалгүй оношлож, тохирсон эмчилгээг зөв хийх нь өвчнийг хүндрүүлэхгүй байх гол нөхцөл болно. Томуугийн эмчилгээнд вирусийн эсрэг бэлдмэлийг ашиглах ДЭМБ-ын удирдамж мөн бий бөгөөд эмч нар үүнийг эмчилгээ хийхдээ мөрдөх нь зүйтэй.

Томуугийн А(Н1N1) 2009 вирусээр сэдээгдсэн өвчлөл хүндрэл өгч болох өндөр эрсдэлтэй хүн амын бүлэгт бага насны хүүхэд, жирэмсэн эмэгтэйчүүд, уушгины багтраа, диабет зэрэг архаг эмгэгтэй хүмүүс орно. Ийм өндөр эрсдэлтэй бүлгийн хүмүүс томуугаар өвчилбөл нэн даруй оселтамивир буюу занамивирээр эмчлэх хэрэгтэй.

**Англи хэлнээс орчуулсан П.Нямдаваа**

<sup>2</sup>ДЭМБ ирэх томуугийн улиралд Дэлхийн бөмбөрцгийн өмнөд болон хойд хагаст хэрэглэхийг зөвлөмж болгосон томуугийн вакцины найрлаганд А(Н1N1) 2009 вирусийг оруулах нь зүйтэй гэж зөвлөж буй болно.

<sup>3</sup>Clinical management of human infection with pandemic (H1N1) 2009: revised guidance, [http://www.who.int/csr/resources/publications/swineflu/clinical\\_management/en/index.html](http://www.who.int/csr/resources/publications/swineflu/clinical_management/en/index.html);

<sup>4</sup>WHO Guidelines for Pharmacological Management of Pandemic (H1N1) 2009 Influenza and other Influenza Viruses, [http://www.who.int/csr/resources/publications/swineflu/h1n1\\_use\\_antivirals\\_20090820/en/index.html](http://www.who.int/csr/resources/publications/swineflu/h1n1_use_antivirals_20090820/en/index.html)